



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 14 өдөр

Дугаар А/578

Мандалговь

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн
сүлд модны наадамд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай" хуулийн 34 дүгээр зүйлийн 2, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 тоот тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 18 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сүлд модны наадмыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зардлыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сүлд модны наадамд зарцуулагдах 700000 (Долоон зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010758

Аймгийн Засаг даргын 2018 оны 12 дугаар
сарын 1-ны өдрийн 458 тоот
захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

| № | Нэр | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|-----------------------------------|----------------------|------------|----------------|---------------|
| Нэг. Аймгийн харьяат иргэд | | | | |
| 1 | Бэлэг | 25 | 20000 | 500000 |
| 2 | Урлагийн арга хэмжээ | 3 | 50000 | 150000 |
| 3 | Бичиг хэрэг | 1 | 50000 | 50000 |
| НИЙТ ДҮН | | | | 700000 |